Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,857.7 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	280,750.5	298,188.5	17,437.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,494.9	-	(2,494.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	278,255.6	298,188.5	19,932.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,123,780.4	1,092,484.9	(31,295.6)
Үндсэн хөрөнгө	2,459,696.7	2,512,609.3	52,912.7
Хуримтлагдсан элэгдэл	(1,335,916.3)	(1,420,124.5)	(84,208.2)
Нийт хөрөнгө	1,404,531.0	1,390,673.3	(13,857.7)
Өр төлбөр	-	274.4	274.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,404,531.0	1,390,398.9	(14,132.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,404,531.0	1,390,673.3	(13,857.7)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Авлагын дансны эхний үлдэгдэл 2,494.9 мянган төгрөгийг тайлант онд байгууллагын дансанд 100 хувь төвлөрүүлж авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 298,188.5 мянган төгрөг болж 19,932.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 59,946.0 мянган төгрөгийн уран бүтээлийн хувцас, урын сантай холбоотой бараа материал, аймгийн онцгой комисс болон ажилчдын хандиваар авсан 3,908.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,512,609.3 мянган төгрөг болж 52,912.7 мянган төгрөгөөр өссөн аймгийн Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 36,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 45,000.0 мянган төгрөгийн автомашин, архивын шүүгээ, төсвийн хөрөнгөөр 5,300.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 44 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газарт 33,600.0 мянган төгрөгийн пургон автомашиныг шилжүүлсэн байна.

Байгууллагын санхүүгийн тайланд 274.4 мянган төгрөгийн өглөгийг залруулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,390,673.3 мянган төгрөг болж 13,857.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 13,857.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв



Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,190,166.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,190,166.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 230,366.1 мянган төгрөгөөр бууруулж 959,800.2 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 2 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 979,203.3 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 979,203.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 979,203.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 978,460.3 мянган төгрөгийг зарцуулж 743.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 978,460.3 мянган төгрөг буюу 99.92 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 474.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 69.6 мянга, хангамж бараа материалын зардал 66.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 26.8 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 105.9 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 30,716.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн А/438 дугаартай “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” захирамжийн дагуу бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 30,376.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд гол зардлыг 13,668.2 мянган төгрөг уран бүтээлийн зардал, 6,900.0 мянган төгрөг notebook зөөврийн яригч худалдан авахад, 1,682.5 мянган төгрөг малын өвс тэжээлийн үнэ эзэлсэн ба 340.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,059,282.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 11,387,286.6 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.


Тус байгууллага нь 2021 онд нийт 979,203.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 791,006.6 мянган төгрөгийн 120 мэдээллийг хугацаанд нь, 188,196.7 мянган төгрөгийн 29 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохижудаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	27	9	
5	Тухай бүр	8	96	78	18	
	Нийт	27	151	120	29	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

Аудитын код **БНА-2022/159/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд орон нутгийн төсвөөс 979,203.3 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 978,460.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 743.0 мянган төгрөг буюу төсвийн 0.1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 198,486.8 мянган төгрөгөөр баталж 198,417.2 мянган төгрөгийг зарцуулж 69.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 22,605.8 мянган төгрөгийн 8 алдаа зөрчилд 3 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 санхүүгийн тайлангийн залруулга, 2,061.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилтийг 100 хувь барагдуулж Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021.10.01-ны өдрийн 78 албан бичгээр төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.07.05-ны өдрийн 64, албан шаардлагын хариуг 2021.03.04-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 256,336.8 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 274,4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 18.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28,219.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага, 227,824.5 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллагын нягтлан бодогч Ч.Энхжаргалын 4 дүгээр сарын гарт олгох цалингаас 206.7 мянган төгрөгийг илүү суутгасан бөгөөд санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд хувь хүнд өгөх өглөгөөр 206.7 мянган төгрөгийг тусгуулж тайланг залруулав.

2. Өндөр настны тэтгэвэрт гарсан тасалбар түгээгч Д.Балданд 2021.04.26-ны өдөр олгосон амралтын цалингаас суутгасан ХХОАТ 47.4 мянга, хамтын сангийн 20.3 мянга нийт 67.6 мянган төгрөгийг шилжүүлээгүй өрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас Аудитын код **БНА-2022/159/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хувиарлалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд татварын хэлтсийн дансанд 47.4 мянга, хамтын санд 20.3 мянга, нийт 67.7 мянган төгрөгийг өглөгөөр тусгуулж тайланг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Бүжигчин У.Дорждэрэмд 2021.11.04-ний өдөр олгосон 610.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалингаас 591.1 төгрөгийг суутгасан боловч үлдэгдэл 18.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5.“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хувиарлалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Бүжигчин У.Дорждэрэмээс дутуу суутгасан цалингийн урьдчилгаа 18.9 мянган төгрөгийг орон нутгий төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 28,219.0 мянган төгрөг төвлөрүүлсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” А/438 дугаартай захирамжийн дагуу 28,219.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019.03.27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын хоёрдугаар зүйлийн 2.2 дахь заалтын дагуу баримт материалыг холбогдох маягтын дагуу бүрдүүлээгүй , нэмэлт орлогыг зарцуулах хүсэлт гаргаагүй нь энэхүү журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үнэн зөв төлөвлөн батлуулж, Сангийн сайдын 2019.03.27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан журмыг мөрдөн ажиллаж, төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах хүсэлтийг аймгийн Засаг даргад тавьж, эрх бүхий байгууллагын шийдвэр, захирамж гараагүй байхад зарцуулдаг явдлыг таслан зогсоохоор албан шаардлага хүргүүлэв.

4.4 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1. Шилэн дансны цахим сайтад нийт 979,203.3 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 791,006.6 мянган төгрөгийн 120 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 188,196.7 мянган төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн Аудитын код **БНА-2022/159/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 29 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2. Тус байгууллага нь тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 198,486.8 мянган төгрөгөөр баталж 198,417.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 39,697.4 мянган төгрөг хэмнэхээс 69.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган 39,627.8 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

3. Нэмэлт санхүүжилтийн данснаас 2021.08.30-ны өдөр 1,682.5 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг сум дундын Ойн ангид шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.”Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно”, 44.1.1.”төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх”, 44.1.2.”туслах үйл ажиллагаанаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх; заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид үндсэн үйл ажиллагааны орлогоос туслах үйл ажиллагаатай холбоотой зардал гаргахгүй байх, мөн Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.1.1, 44.1.2 дэх заалтуудыг мөрдөж ажиллах

4.Тус байгууллагын нягтлан бодогч ажилтай Ч.Энхжаргал нь санхүүгийн тайлангийн аудитын явцад нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээтэй холбоотой шийдвэр, анхан шатны баримтыг бүрдүүлж өгөлгүй зохисгүй үйлдэл гаргасан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.8.өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид дахин алдаа зөрчил давтан гаргахгүй ёс зүйтэй байж, төсвийн нэмэлт орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой шийдвэр, тайлагналыг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын дагуу гаргаж ажиллах анхааруулга зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

			/мянган төгрөгөөр/
Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
	Ауд итад хамр	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	



Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ		1	1			1			

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	6	28,512.3	2	274.4	1	18.9	1	28,219.0	2	
	Дүн	6	28,512.3	2	274.4			1	28,219.0	2	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Шилэн данс	1	188,196.7							1	188,196.7
2	ЗГ-ын 43 дугаар тогтоол	1	39,627.8							1	39,627.8
	Дүн	2	227,824.5							2	227,824.5
	НИЙТ ДҮН	8	256,336.8	2	274.4	1	18.9	1	28,219.0	4	227,824.5



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 38/А0570643 /Б.НА
2022 /159/НА-СТА-ТЦЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” А/438 дугаартай захирамжаар төсөвт байгууллагуудын нэмэлт орлогыг зарцуулах хуваарийг хавсралтаар батлаагүй байхад дээрх шийдвэрийг үндэслэн аймгийн Хөгжимт драмын театр нь 2021 онд үйлчилгээний орлогыг төлөвлөөгүй атлаа байгууллагын үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр 28,219.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтын дансандаа төвлөрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019.03.27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дөрөвдүгээр зүйлийн 4.4 “Соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөвт байгууллагын батлагдсан төлөвлөгөөнөөс давсан орлогыг энэхүү журмын 4.3-т заасны дагуу санхүүжүүлж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар

d:\2022.албан шаардлага.docx

005040054

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж, давсан орлогыг холбогдох шийдвэр гаргуулан Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу зарцуулж байх.

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 02-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Ч.Энхжаргал нарт хариуцуулав².

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН ³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

Л.ДОРЖХАНД

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 34/А0570643/БНА
2022/159/НА-СТА-ТЦЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүжигчин У.Дорждэрэмд 2021.11.04-ний өдөр олгосон 610.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгож 18.9 мянган төгрөгийг дутуу суутгаж тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийг 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бүжигчин У.Дорждэрэмээс дутуу суутгасан цалингийн урьдчилгаа 18,900.0/Арван найман мянга есөн зуун/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

d:\2022.акт.docx

005050063

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2022 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хөгжимт драмын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Ч.Энхжаргал нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

АУДИТОР

Л.ДОРЖХАНД



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно